

ТУСГАЙ ТЭТГЭМЖИЙН ТАЛААР

Япон улсын засгийн газраас хүн бүрт олгох 100,000 иений тусгай тэтгэмж болон үүнд бүртгүүлэх талаар товч танилцуулга.

Хэн авах боломжтой? – Рэйва 2 оны 4-р сарын 27-ны өдрийн байдлаар япон улсад суурин амьдрах хаяг бүртгэлтэй хүн.

Хэзээнээс олгох? – Тухайн хот, дүүргийн захиргаа бүр бүртгэлийн өдрийг товлж, хуудсыг шуудангаар илгээнэ. Бүртгэл эхлэснээс 3 сарын дотор бүртгүүлнэ.

Хэрхэн бүртгүүлэх? – Халдвар тархахаас сэргийлж бүртгэлийг онлайн болон шуудангаар явуулна. Бүртгэлийн хуудаст овог нэр, төрсөн өдөр зэрэг хувийн мэдээллийг бичиж илгээнэ.

Шуудан бүртгэл	Бүртгэлийн хуудаст тэтгэмжийн мөнгө хүлээн авах банкны данс болон шаардлагатай материалыг хавсаргаж харьяагдах хот, дүүргийн захиргаанд илгээнэ.
Онлайн бүртгэл	“My number card”-тай бол албан цахим хуудсаар бүртгүүлнэ.

- Бүртгэлд бичигдсэн данс руу тухайн ам бүлийн гишүүдийн тоогоор дүн нэгтгэн шилжүүлнэ.
- Банкны дансгүй бол харьяа хот, дүүрэгт хандана уу. Хүлээн авах цонхон дээр олгоно.

► Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линк эсвэл QR code холбоосоор орж үзнэ үү.

<https://kyufukin.soumu.go.jp>

► Холбогдох утас: Тусгай тэтгэмжийн талаар утсаар мэдээлэл өгөх төвийн

Төлбөргүй дугаар: 0120-260020

(5/2-ны өдрөөс ажлын болон амралтын бүх өдрүүдэд 09:00~18:30 цагийн хооронд ажиллана.)

Ердийн дугаар: 03-5638-5855

(5/1-ны хүртэл ажлын өдрийн 09:00~18:30 цагийн хооронд ажиллана.)

Залилангаас болгоомжил!!

Тус тэтгэмжийг олгоход хот, дүүргийн захиргаанаас дараах зүйлсийг **ОГТ ХИЙХГҮЙГ** анхаарна уу.

- Банкны АТМ-ээр ямар нэг бүртгэл болон мөнгө олгохгүй.
- Тус тэтгэмжийн мөнгөнөөс суутгал, шимтгэл авахгүй.

Сүүлийн үед “Бүртгүүлэхэд тань туслана” зэргээр хувийн мэдээллийг авах гэсэн залилангийн үйлдэл гарч байна. Иймд иргэд сэжиг бүхий имэйл болон түүний хавсаргасан цахим хуудас руу нэвтрэхгүй байхыг анхааруулж байна. Хэрэв сэжигтэй үйлдэлд өртсөн бол дараахи газруудтай яаралтай холбоо барина уу:

-Харьяа хот, дүүрэг болон ойрхон цагдаагийн алба, Цагдаагийн #9110, Үйлчлүүлэгчийн гомдол хүлээн авах #118 болон Шинэ төрлийн корона вирусын Тусгай тэтгэмжийн мөнгөтэй холбоотой иргэдийн гомдол санал хүлээн авах 0120-213-188 дугаар руу залгана уу.

Нийтлэг асуултууд

“My number card” -гүй бол онлайнаар бүртгүүлэх боломжгүй юу?

Онлайнаар бүртгүүлэхэд “My number card” зайлшгүй шаардлагатай тул тус карт байхгүй тохиолдолд шуудангаар бүртгүүлнэ үү.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэлтэй хаягнаас өөр хот, дүүрэгт амьдардаг бол яах вэ?

Тусгай тэтгэмжийг авахын тулд цаг алдалгүй бүртгэлтэй хот, дүүргийн захиргаанд мэдэгдэж асуудлыг шалгуулна уу. Дэлгэрэнгүйг харьяа хот, дүүргийн захиргаанаас тодруулна уу.

Гадаадын иргэнд Тусгай тэтгэмжийг олгох уу?

Рэйва 2 оны 4 сарын 27-ны өдрийн байдлаар япон улсад суурин амьдрах хаяг бүртгэлтэй бол тусгай тэтгэмжийг авах боломжтой.

Харин богино хугацааны визтэй эсвэл хууль бусаар оршин сууж буй гадаадын иргэд хаяг бүртгэлгүй учир тусгай тэтгэмжинд хамрагдах боломжгүй.

Бүртгэлийн хуудаснаас гадна ямар бичиг баримт бэлтгэх шаардлагатай вэ?

Бүртгүүлэх хэлбэрээс шалтгаалан бүрдүүлэх бичиг баримтууд өөр байна.

Шуудан
бүртгэл

1. Хувийн үнэмлэх бичиг, баримтууд:

“My number card”, Жолооны үнэмлэх, Эрүүл мэндийн даатгалын карт, Гадаад иргэдийн бүртгэлийн үнэмлэх зэрэг бичиг баримтуудын хуулбар хуудас.

2. Тэтгэмжийн мөнгийг хүлээн авах банкны мэдээлэл:

Банкны дэвтэр, банкны карт, интернэт банкны хуулбар хуудас. (Данс эзэмшигчийн овог нэр, дансны дугаар, банкны нэр, салбар зэрэг бүх мэдээлэл тод харагдах.)

Онлайн
бүртгэл

1. Хувийн үнэмлэх бичиг, баримтууд:

“My number card” –ийн хувьд гарын үсгээр баталгаажуулагдах тул бусад хувийн нотлох бичиг шаардлагагүй.

2. Тэтгэмжийн мөнгийг хүлээн авах банкны мэдээлэл:

Банкны дэвтэр, банкны карт, интернэт банкны зураг. (Данс эзэмшигчийн овог нэр, дансны дугаар, банкны нэр, салбар зэрэг бүх мэдээлэл тод харагдах.)

Дэлгэрэнгүйг: Тусгай тэтгэмжийн талаар утсаар мэдээлэл өгөх төвийн

0120-260020 төлбөргүй дугаарлуу залгаж лавлана уу.